

## **ДАЛАЙД ГАРЦГҮЙ УЛСУУДЫН ДАЛБААГАА МАНДУУЛАХ ЭРХИЙГ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРСӨН ТУХАЙ ТУНХАГЛАЛ**

Үүний тулд зохих ёсоор бүрэн эрх олгогдсон дор гарын үсгсс зурагсад тэдний төлөөлж улс гүрнүүдээс далайд гарцгүй ямар ч улсын хөлөг онгоцуудын далбаагаа мандуулах эрхийг хүлээн зөвшөөрч байгааг зарлан тунхаглаж байна.

Эдгээр хөлөг онгоц нь тухайн улсын нутаг, дэвсгэрт тодорхой нэгэн газар бзртгэлтэй байвал зохих бөгөөд энэ газар нь тэдгээрийн бүртгэлийн боомт хот байх болно.

1921 оны Дөрөвдүгээр сарын 20 – ны өдөр Барселона хотноо нэг хувь үйлдсэн бөгөөд франц, англи эх нь адил хүчинтэй байна.